ХУУЛЬ ТОГТООМЖ,ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
/2025 оны жилийн эцсийн байдлаар /

Орхон аймаг 2025 оны 12 дугаар сарын 16

| № | Тогтоол шийдвэрийн нэр огноо, дугаар | Хүчинтэй байх хугацаа | Арга хэмжээ | Хэрэгжилтийн явц | Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ | Үр нөлөө Нотлох баримт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | МУ-ын хууль №2022.04.29, 2022-04-29 | Төрийн хэмнэлтийн тухай | 8.2. Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй. | Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь эмч,эмнэлгийн мэргэжилтэн, инженер техникийн ажилчид, түргэн тусламжийн жолооч,эмч нийт 513 хүнд нийт 55,0 сая төгрөгийн санхүүжилтээр ажлын хувцас олгож, хөдөлмөр эрүүл ахуйн аюулгүй байдлыг ханган ажилласан. Эрүүл мэндийн газрын албан хаагч нарын тусгай хувцаст шаардагдах зардлыг хэмнэлтийн тухай хуулийн дагуу олгоогүй байна. | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцасны бүртгэл судалгааг гаргаж, ажилтан бүр дээр бүртгэлжүүлэн ашиглалтын байдалд хяналт тавин ажиллаж байна. | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 513 ажиллагсдыг 100% хөдөлмөр хамгааллын хувцсаар шинэчлэн хангасан байна. Ингэснээр ажилчдын хөдөлмөр хамгаалал,эрүүл ахуйн аюулгүй байдлын журмын хэрэгжилт 100% хангагдсан байна. | 100 |
| 2 | МУ-ын хууль №, 2021-12-17 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл Эзэмшигчийн нэр, х4аяг, салбар, тө5лөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа | Тусгай зөвшөөрөл олгох хурлыг нийт 10 удаа хуралдуулж 49 байгууллагын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд сунгалт 7, эрх сэргээлгэсэн 2, түдгэлзүүлсэн 7, хүчингүй болгосон 8, хаягийн шилжилт 5, төсөл 12, шинээр 11 байгууллагад зөвшөөрөл олгосон.<br>Ажлын байранд 3-5 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй баг батлагдсан удирдамжийн дагуу 11 удаагийн үнэлгээг хийж, тусгай зөвшөөрлийн хурлаар дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.<br>Тусгай зөвшөөрөлийн хүрээнд нийт 72 эмийн санд мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналт, 13 эрсдэл өндөртэй эмийн санд тусгай зөвшөөрлийн хүрээнд хяналт үнэлгээг хийж, эм, биобэлдмэлийн улсын байцаагчид 5 зөрчил шалгуулахаар | ЭМГ-ын вэб хуудас болон shilen.gov.mn-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал, хууль эрх зүйн баримт бичгүүдийг байршуулан иргэдэд нээлттэй , мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн хүрээнд хаягийн шилжилттэй холбоотой 2 иргэний гомдлыг эрүүл ахуйн хяналтын улсын | Дээрх эмийн сангуудад 2 удаагийн сургалт, мэдээллийг 70 эмч зүйч, эм найруулагч нарт зохион байгуулсан. Цахим хөгжлийн яамнаас ирүүлсэн мэдээллийн дагуу ЗДТГ-ын ХЭЗХ-т тусгай зөвшөөрлийн талаарх 3 чиглэлийн мэдээлллийг гарган хүргүүж,мэдээллийн нэгдсэн цахим програм(license)-ын цахим сургалтыг зохион байгуулж, ЭМЯ-нд тусгай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шилжүүлж, 2 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.ЭМЯ-нд тусгай зөвшөөрөл олгох, Зөвшөөрлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой 11 саналыг нэгтгэж хугацаанд нь хүргүүлсэн. | байцаагчийн хамт ажлын байранд 4 удаагийн хяналтыг хийж шийдвэрлэсэн | зөвшөөрөлтэй 167 байгууллагын мэдээллийг хүргүүлэн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж ажилласан. | |
| МУИХ-ын тогтоол | | | | | | | |
| 3 | УИХ-ын тогтоол №62, 2019-06-06 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай | 1.4/в/. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах; | Аймгийн хэмжээнд анхан шатны 9 байгууллага (сумын эрүүл мэндийн төв - 1, өрхийн эрүүл мэндийн төв - 8), эмэгтэйчүүдийн хувийн хэвшлийн үүдэн клиник - 7, төрөлжсөн мэргэшлийн - 1 (Эрдэнэт Медикал), нэгдсэн эмнэлэг - 1 (Баян-Өндөрмед), лавлагаа шатлалын Бүсийн оношилгоо эмчилгээний төв нөхөн үржихүй, жирэмсэн, төрөх, төрсний дараах тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төрөх тасгийн засварт 2,2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс гаргахаар 2026 оны аймгийн төсөвт суугдаж, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрөх тасгийн төлбөртэй өрөөнд 16,5 сая төгрөг цугларч, үүнээс эд хогшилд 11,1 сая, засварт 809,600 төгрөг зарцуулсан байна. "Ээж минь" төслийн хүрээнд сайн дурын байгууллага БОЭТ-ийн төрөх тасгийн 6 нойлыг бидэ суултуур болгон засварлаж, тусламж үйлчилгээний нөхцөлийг сайжрууллаа. Тайлант хугацаанд эх, хүүхэд, нөхөн үржихүйн чиглэлээр танхимаар 445 хүнд, цахимаар 32,886 хүнд нийт 33,331 хүнд нөхөн үржихүйн мэдээлэл хүргэсэн байна.Сум, өрхийн 8 эрүүл мэндийн төвийн эх баригч нарыг нөхөн үржихүйн зөвлөгөө өгөх ур чадвар олгох ажлын байрны сургалтад 4 удаа хамруулсан. | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг олгох ЭМБ-уудын үйл ажиллагааг эрчимжүүлэн, жирэмсэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж үйлчилгээг үзүүлэх ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр дэмжлэгт хяналт, аян зохион байгуулах, мэдээ мэдээллийн урсгалыг сайжруулах, сум, өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эх баригч нарыг чадавхжуулах зэрэг зөвлөмжөөр ЭМБ-уудыг хանган ажилласан.Иргэдийн мэдээлэл авах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр биеэр, цахимаар, танхимаар, утсаар, фэйсбүүк группээр, брошюраар зэрэг 6 сувгаар хүргэж, тусламж үйлчилгээг амбулатори, өдрөөр, гэрээр, хэвтэн эмчлүүлэх гэсэн 4 хэлбэрээр үзүүлж байна. | Тайлант онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн насны ХБИ-тэй 676 эмэгтэй байгаагаас урьдчилан сэргийлэх үзлэгт 508 (75.15%) эмэгтэйг, зорилтот бүлгийн 926 (57.48%)-ийг жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэлд хамруулсан байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат, бие засах 00-ийн өрөөг бүрэн тохижуулсан, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгч нарт ээлтэй байдлаар зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | УИХ-ын тогтоол №2024-24, 2024-04-18 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай | Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай. | ЭМГ-ын ёс зүйн дэд хорооны 2025 төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх,соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэй 98%-тай байна. ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмыг батлуулан ТАХ-ын ёс зүйн тухай хууль, ажлын байранд тавигдах шаардлагыг тогтмол сануулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 12 постерийг 32 албан хаагчдад түгээж, ТАХ-ийн ёс зүй манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор төрсөн өдөр нь тохиосон 25 албан хаагчид ёс зүйг сануулсан мэндчилгээг хүргэсэн."Еннеаграм ба Урлагийн сэтгэл засал", "Хувь хүний хөгжил" сэтгэл зүйн сургалтыг "Амьдралын зөв хараа" НҮТББ-тай хамтран еннеаграмын тухай ойлголт, 9 төрөлт зан чанарын тодорхойлолт, онцлог харьцаа, хоршлын талаар мэдлэг нэмэгдэж, багаар ажиллах арга барил, урлагийн олон талт дасгалуудыг хийж стрессээ зөв тайлах арга зүйд суралцсан.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмаар асуулт хариултын тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Тус тэмцээнд 18 албан хаагч хамрагдаж төрийн албан хаагчийн ёс зүйн 6 зарчим, салбар зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийн мэдлэг нэмэгдэж ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах шаардлага, хориглох зүйлсийн мэдлэг 55%-иар нэмэгдсэн байна. Тэмцээнд тэргүүлсэн 8 албан хаагчийг урамшуулсан. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулан,ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 удаагийн танхим 4 удаагийн цахим сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.Шинээр ажилд орсон 5 албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" "ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журам" "Хөдөлмөрийн дотоод журам" сэдвүүдээр сургалт хийж ёс зүйн баталгааг гаргуулсан авсан. Мөн эрэгтэй албан хаагчдад "Эмэгтэй албан хаагчидтай хэрхэн харилцах вэ" сэдвийн хүрээнд хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулж чадавхжуулсан. | Төрийн албаны хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн, төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ухамсар, манлайллыг нэмэгдүүлж, ажлын байран дахь ёс зүйн эрсдлийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулсан байна. ЭМГ-ын албан хаагчдаас "Төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдлийг тодорхойлох" эрсдлийн үнэлгээгээр ёс зүйн зөрчил эсвэл эрсдэлтэй холбоотой үйлдлийг огт хийдэггүй гэж хариулсан 64,8%, заримдаа 20.4%, ихэнхдээ 14,8% гэсэн хариултыг илгээсэн бөгөөд ёс зүйн эрсдэл 25.1% -тай дүгнэгдсэн байна. | 100 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 5 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол №04, | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын | 2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах | Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг нэмэгдүүлэх чиглэлээр 510 сая төгрөгийг батлуулан зарцуулснаас | Зорилтот бүлгийн хүн амыг ялангуяа нөхөн үржихүйн үзлэг, эрэгтэйчүүд, оюутан залуусын дундахь | Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2.9 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016-12-14 | тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх | зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих. | орон нутгийн төсвөөс "Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн 23 удаагийн арга хэмжээнд хамруулахад 110,0 сая төгрөг зарцуулж, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, хүний папилома вирусын халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтад Боловсролын газар, сум, 9 өрхийн эрүүл мэндийн төв, Амурлин тэнгис ТББ-уудтай хамтран 3 арга хэмжээг зохион байгуулж, 4750 сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллийг хамруулсан байна. -Цагаан тоосны нөлөөллийн бүсэд амьдарч буй 1,866 иргэнээс эрсдэл өндөртэй 500 иргэнийг хяналтат үзлэгт хамруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, цагаан тоосны нөлөөлөл болон түүнээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр хяналт, үзлэг, сургалт, мэдээлэл түгээх 12 удаагийн төрлийн арга хэмжээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 400 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна. Орон нутгийн 2025 оны төсвөөс улаан бурхан, томуу томуу төст өвчний дэгдэлтийн үеийн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээг чадавхжуулах зорилгоор нийт 155,0 сая төгрөгийг шийдүүлэн ЭМБ-уудад шаардлагатай оношлуур, багаж тоног төхөөрөмж, шатахуун, эм,эмнэлгийн хэрэгсэлд зарцуулж, хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлж ажилласнаар өвчлөл эндэгдэл багатай даван туулсан. | бэлгийн замын халдвар, ДОХ, тэмбүүг илрүүлэх үзлэг зохион байгуулах, хавьтлын хамт эмчлэн эрүүлжүүлэх хяналтад авах, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг нээлттэй хаалганы өдөр, эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр, зорилтот бүлгийн үзлэг зэрэг 18 удаагийн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай төсвийг орон нутгаас шийдүүлэх хүний нөөц, оношлуур,эм урвалжийн хангалтыг нэмэгдүүлэн, үзлэг шинжилгээнд хамралтыгсайжруулахад чиглэсэн төлөвлөгөө гаргаж, Засаг даргын захирамж 3, тушаал 4, удирдамж 11 -ийг боловсруулан хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ төлөвлөж,хэрэгжилт 92,5% -тай хэрэгжсэн. | промиллоор буурсан байна.Нийт халдварт өвчний 51.5% амьсгалын зам, 23.7% БЗДХ, 4.7% гэдэсний, 20.2% бусад халдварт өвчин байна. 4 төрлийн 225 хам шинж, сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, бүртгэл мэдээлэл, хавьтлын хяналт тандалт, эмчлэн зэрэг хариу арга хэмжээг авч ажилласан байна. | |
| 6 | УИХ-ын Байнгын хорооны | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний | 2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан | ХДХВ/ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг Орхон аймгийн ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн | Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх нэгдсэн төлөвлөгөөг | Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоол №04, 2016-12-14 | дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай | аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах; | зорилт (2026)-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.2.5, Эрүүл мэндийн сайд, Засаг даргын хамтран ажиллах гэрээний 3.10.7,Засаг даргын үйл ажиллагааны 2024-2028 төлөвлөгөөнд тусган хэрэгжилт 84,5%-тай байна.ХДХВ/ДОХ,БЗДХ-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчин 2020 онд 295, 2021 онд 208, 2022 онд 170 , 2023 онд 148, 2024 онд 151, 2025 онд 153 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 14,4 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,2 промиллоор өссөн бөгөөд хавьтагчийн хамт хяналт эмчилгээнд 100% хамруулсан.Тайлант хугацаанд анхан болон лавлагаа шатлалын байгууллагуудаар ХДХВ/ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн сорилд 9546 хүнийг хамруулан эерэг илэрсэн 164 тохиолдлыг оношилгоо хяналтад авч, зориудын 6 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаагийн цэрэг татлага, хорих анги, ААНБ-уудын эрэгтэйчүүд, МСҮТ,их дээд сургуулийн оюутан нийт 25995 хүнийг ХДХВ/ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн сорилд хамруулсан.ДОХ/ХДХВ-ийн халдвар эмнэлгийн нөхцөлд дамжих тархахаас сэргийлэх журмыг батлан мөрдөж эрт илрүүлэг, жирэмсэн, яаралтай хагалгаанд орж байгаа үйлчлүүлэгчдийг 100% ДОХ/ХДХВ-ийн шинжилгээнд хамруулж хэвшсэн байна. | батлуулан хэрэгжилт 84,5%-тай хэрэгжсэн байна. Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад салбар дундын байгууллагуудын оролцоог хангаж, зорилтот бүлгийг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, өсвөр үеийн хүүхэд залуучууд, оюутан, цэрэг татлага гэх зэргээр тодорхойлон нээлттэй хаалганы өдөр, зорилтот бүлгийн үзлэгийг удирдамжийн дагуу зохион байгуулж, шаардагдах оношлуур,эм,эмнэлгийн хэрэгслээр хангахад шаардлагатай 15,0 сая төгрөгийн төсвийг орон нутгийн төсвөөс шийдүүлсэн байна. 2025 онд бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгаанд нийт 42144 иргэнийг хамруулсан байна. | бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2.9 промиллоор буурсан байна.Нийт халдварт өвчний 51.5% амьсгалын зам, 23.7% БЗДХ, 4.7% гэдэсний, 20.2% бусад халдварт өвчин байна. 4 төрлийн 225 хам шинж, сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, бүртгэл мэдээлэл, хавьтлын хяналт тандалт, эмчлэн зэрэг хариу арга хэмжээг авч ажилласан байна. Рийл 4, цахим зөвлөгөө 3, ярилцлага тус бүр 1 удаа цахим хуудаст байршуул, 6726 хүнд хүрч, Эрүүл мэндийн салбарын 15, орон нутгийн 4 цахим хуудсаар мэдээлэл, сэрэмжлүүлэг зөвлөмж түгээж, 32 зурган болон видео шторк мэдээллийг давхардсан тоогоор 16468 хүнд хүргэж, 117 цахим хуудаст түгээсэн байна. | |
| 7 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол №10, 2016-05-01 | НББСШУБХ. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг | хүн амын эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон зөвлөгөө өгөх төвд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. | Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, хүний папилома вирусын халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтад Боловсролын газар, сум, 9 өрхийн эрүүл мэндийн төв, Амурлин тэнгис ТББ-уудтай хамтран 3 арга хэмжээг зохион байгуулж, 4750 сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч | Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн удирдамж батлуулан салбаруудад хүргүүлж ажиллаж, биелэлтийг | Сүрьеэгийн өвчлөлийн 70 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 6,6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,7 промиллоор буурч,эмчилгээнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай | | нарын төлөөллийг хамруулаад байна. -Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг "Асуудлыг шийдье, ДОХ-ын эсрэг хариу арга хэмжээг сайжруулъя" уриан дор ЭМГ, БОЭТ, "Амурлин тэнгис" ТББ-тай хамтран "БЗДХ/ХДХВ/ДОХ гэж юу вэ?", "Өсвөр үеийн сэтгэлзүйн онцлог ба сэтгэцийн эрүүл мэнд","БЗДХ-аас сэргийлэх арга замууд" сэдэвт сургалтад 450 оюутан, сурагчдыг хамруулан танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж, сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэн мэдлэгийг бататгасан. "Улаан тууз" сэдвээр ЕБС-ын сурагчдын дунд богино бичлэгийн уралдаан зарлаж, 150 гаруй хүүхдүүд хамрагдсан байна. Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо, сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо, Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгтэй хамтран ЭМГ-аас сум, өрхийн эрүүл мэндийн 8 төвүүдээс сүрьеэгийн эрсдэлт бүлгийн 3790 хүний судалгааг гаргаж, 1872/49.4%/ хүнийг сүрьеэгийн идэвхтэй илрүүлэгт хамруулж, 198 хүнд сорил, 15 хүнд цэрний шинжилгээ хийж, эмчилгээ идэвхтэй хяналтад авсан байна.Сорил эерэг гарсан 34 хүнийг урьдчилан сэргийлэх, 1 тохиолдлыг эмэнд мэдрэг сүрьеэгийн /ЭМС/ эмийн эмчилгээнд хамруулан хяналтад авсан байна. | 88,5% хангаН ажиллалаа. Цэрэг татлагын 2 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэгт 18-25 насны 499 залуучуудыг хамруулж, БЗДХ-ын 4, сүрьеэгийн сэжигтэй 8 тохиолдлыг илрүүлж бүртгэл, хяналтад хавьтлын хамт авсан.Тайлант хугацаанд жирэмсний идэвхтэй хяналтад байгаа 914 жирэмсэн эхийг сүрьеэгийн тандалт асуумжид хамруулан жирэмсэн үеийн сүрьеэ өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.Сүрьеэ өвчний илрүүлэг, мэдээллийн урсгалболон оношилгоо, хяналт, эмчилгээнд анхаарах асуудлаар салбар дундын уялдааг хангах хэлэлцүүлэг 1 удаа,чадавхжуулах сургалтад давхардсан тоогоор анхан болон лавлагаа шатлалын 124 эмч,эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. | орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь 63,6%-д хүрсэн нь суурь түвшнөөс 39,8%-иар нэмэгдсэн эерэг үр дүнд хүрсэн байна.Аймгийн хэмжээнд бүртгэгдэж байгаа халдварт өвчний тохиолдлуудад тандалт судалгааг тогтмол хийж, илрүүлэг, хяналт, тандалт, эмчилгээ зэрэг хариу арга хэмжээг авч ажиллахад төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран ажилласан. | |
| 8 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол №10, 2016-04-05 | НББСШУБХ. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг 3бууруулах, хязгаарлах, урьдчилан | Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг | Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 65 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 6,1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2,5 промиллоор буурч, бэлгийн замаар дамжих халдварын 153 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 14,4 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,2 промиллоор өссөн байна. Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр батлуулсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд салбар | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах чиглэлээр батлуулсан эрсдлийн удирдлагын хөтөлбөр, ЭМС-аас аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээнд тусган, хэрэгжилтийг | Тайлант хугацаанд жирэмсний идэвхтэй хяналтад байгаа 914 жирэмсэн эхийг сүрьеэгийн тандалт асуумжид хамруулан жирэмсэн үеийн сүрьеэ өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. .Дэлхийн ДОХ-той | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай - | зохион байгуулах | дундын хэлэлцүүлэг 1, эмнэлзүйн сургалт 2 удаа, сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг 5 аж ахуйн нэгж байгууллага, 1 ТББ-тай хамтран зохион байгуулж, биелэлт 88,5%-тай ханган ажиллаж, 124 эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан.Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд эрсдэлт бүлгийн 3790 хүний судалгааг гаргаж, 1872/49.4%/ хүнийг сүрьеэгийн идэвхтэй илрүүлэгт хамруулж, 198 хүнд сорил, 15 хүнд цэрний шинжилгээ хийсэн. Сорил эерэг гарсан 34 хүнийг урьдчилан сэргийлэх, 1 тохиолдлыг эмэнд мэдрэг сүрьеэгийн эмийн эмчилгээнд хамруулсан. Цэрэг татлагын 2 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэгт 499 залуусыг хамруулж, БЗДХ-ын 4, сүрьеэгийн сэжигтэй 8 тохиолдлыг илрүүлж бүртгэл, хяналтад авсан.<br>Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол бүртгэгдэж, 23.7%-ийг БЗДХалдварт өвчин эзэлж байгаагаас 42.6 % тэмбүү, 41.4% трихомониаз, 15.4%-ийг заг хүйтэн эзэлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 21 тохиолдол буюу 1.9 п/м-ээр нэмэгдэж, төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдол бүртгэгдсэн. БЗДХКабинетаар урьдчилан сэргийлэх үзлэг 4004, диспансерын хяналтын үзлэг 386, өвчний учир 649, нийт 5039 хүнд үзлэг оношилгоо хийгдсэн. | хангаж ажиллан хэрэгжилт 86,4%-тай байна.2025 онд Амарлин тэнгис ТББ-тай хамтран бэлгийн замаар дамжих халдвар,ХДХВ-ийн халдварын тархалтыг илрүүлэх үзлэг шинжилгээг 3 удаа , БЗДХӨ-нөөс сэргийлэх сургалт сурталчилгаа нөлөөллийн 6 ажлыг ЭМБ-уудтай хамтран зохион байгуулсан. Тайлант хугацаанд анхан болон лавлагаа шатлалын байгууллагуудаар ХДХВ/ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн сорилд 9546 хүнийг хамруулан эерэг 164 тохиолдлыг оношилгоо хяналтад авч, зориудын 6 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаагийн цэрэг татлага, хорих анги, ААНБ-уудын эрэгтэйчүүд, МСҮТ,их дээд сургуулийн оюутан нийт 25995 хүнийг хамруулсан. | тэмцэх өдрийг "Асуудлыг шийдье, ДОХ-ын эсрэг хариу арга хэмжээг сайжруулъя" уриан дор ЭМГ, БОЭТ, "Амурлин тэнгис" ТББ-тай хамтран "БЗДХ/ХДХВ/ДОХ гэж юу вэ?", "Өсвөр үеийн сэтгэлзүйн онцлог ба сэтгэцийн эрүүл мэнд","БЗДХ-аас сэргийлэх арга замууд" сэдэвт сургалтад 450 оюутан, сурагчдыг хамруулан танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж, идэвх оролцоог нэмэгдүүлэн мэдлэгийг бататгасан. "Улаан тууз" сэдвээр ЕБС-ын сурагчдын дунд богино бичлэгийн уралдаан зарлаж, 150 гаруй хүүхдүүд хамрагдсан байна.Эрүүл мэндийн 9 салбарын цахим хуудсанд 5 төрлийн зурган зурагт хуудас байршуулж нийт 24175 хүнд хүргэсэн байна. | |
| 9 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол №2025_ 04, 2025- | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд | Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. Тайлант хугацаанд тус дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс | Ёс зүйн дэд хороо нь Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн | Төрийн албаны хаагчийн ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа тогтмолжсоноор албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 06-10 | | олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах. | зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэлээр 2 зорилтын хүрээнд нийт 23 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлснээс 21 нь бүрэн хэрэгжиж, үйл ажиллагааны гүйцэтгэл 98%-тай байна. Албан хаагчдын ёс зүйн төлөвшил, ажлын байрны сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын албан тушаалтан бүрийн ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхой болгон, холбогдох журмыг батлуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд улирал тутам соён гэгээрүүлэх сургалт, төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулсан. Үүнтэй уялдуулан 2025 онд ёс зүйн зөрчлийн эрсдэлийн үнэлгээг хийж, нийт эрсдэлийг 25.1% гэж дүгнэсэн. | үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэлээр 2 зорилтын хүрээнд нийт 23 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлснээс 21 нь бүрэн хэрэгжиж, үйл ажиллагааны гүйцэтгэл 98%-тай байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооны дарга болон гишүүдийн урамшууллын санхүүгийн эх үүсвэр одоогоор шийдэгдээгүй байна. Уг үнэлгээнд үндэслэн төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Эрүүл мэндийн газрын ажлын байрны шаардлагын талаарх сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулж, үр дүнд нь албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг 25%-иар нэмэгдсэн байна. | урьдчилан сэргийлсэн, төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ухамсар, манлайллыг нэмэгдүүлж, ажлын байран дахь ёс зүйн эрсдлийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулсан бөгөөд тайлант хугацаанд төрийн албан хаагчтай холбоотой гомдол санал бүртгэгдээгүй байна. | |
| 10 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол №2025_04, 2025-06-10 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай | Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх. | Аймгийн Эрүүл мэндийн газар, БОЭТ-д Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо байгуулагдсан. Тайлант хугацаанд 5 удаа хуралдаж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 23 ажлыг хийхээр төлөвлөн батлуулж үйл ажиллагааны хэрэгжилт 98%-тай байна. Ёс зүйн дэд хороодын гишүүд нь хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгаа хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийгдсэн. Үүнд. Эрүүл мэндийн газрын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмыг батлуулан, гишүүдийн эрх, үүргийг тодорхой тусган Эрүүл мэндийн газрын даргын А тушаал 54, Б тушаал 24 | Ёс зүйн дэд хороодын гишүүд нь хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх журмыг батлуулан хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр 6 үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу багаар зохион | Ёс зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийгдэж, тушаал, шийдвэрүүдийг ёс зүйн хууль тогтоомжид нийцүүлэн баталснаар байгууллагын ёс зүйн соёл төлөвшиж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлагдсан бөгөөд тус тушаал шийдвэрүүд нь төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцсэн байна.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэгт ЭМГ, БОЭТ-ийн Ёс зүйн дэд хорооны дарга нар , "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал бүсийн зөвлөгөөн"-д ёс зүйн хорооны гишүүд болон албан хаагчид хамрагдан чадавхжсан байна. | байгуулсан. "Еннеаграм ба Урлагийн сэтгэл засал", хувь хүний хөгжил, сэтгэл зүйн сургалт,"Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" болон ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах шаардлагаар нийт 33 албан хаагч дунд асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулж, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тодорхойлох" асуулгыг цахимаар авч эрсдэлийг тодорхойлсон байна. | албан хаагчдын хариуцлага, мэдлэг, ойлголт дээшлэн дотоод зохион байгуулалт сайжирсан. | |
| 11 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол №2025_04, 2025-06-10 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангаж үр дүнд хяналт тавьж ажиллах; | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан ЭМГ-ын дэргэдэх төрийн албан хаагчийн ёс зүйн хорооны 2025 үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.<br>Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд улирал тутам соён гэгээрүүлэх сургалт, төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ТАХ-ын ёс зүйн дэд хорооны ажиллах журам,шинээр ажилд орсон албан хаагчдыг чиглүүлэх 8 цагын сургалт "ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журам" "Эрүүл мэндийн газрын хөдөлмөрийн дотоод журам" "Ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх багц" сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 112 албан хаагч хамрагдан албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг 23%-иар нэмэгдсэн байна. | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, 112 албан хаагчийг хамруулсан. | Нийт албан хаагчдын дунд ёс зүйн зөрчил тайлант онд бүртгэгдээгүй байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 98%-тай хэрэгжсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол №2024-06 ЁЗДБХ, 2024-11-06 | Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай | Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах. | Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. Тайлант хугацаанд тус дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэлээр 2 зорилтын хүрээнд нийт 23 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлснээс 21 нь бүрэн хэрэгжиж, үйл ажиллагааны гүйцэтгэл 98%-тай байна.<br>Албан хаагчдын ёс зүйн төлөвшил, ажлын байрны сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын албан тушаалтан бүрийн ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхой болгон, холбогдох журмыг батлуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд 23 үйл ажиллагааг төлөвлөж үйл ажиллагааны хэрэгжилт 98%-тай байна | Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд улирал тутам соён гэгээрүүлэх сургалт, төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулсан. Үүнтэй уялдуулан 2025 онд ёс зүйн зөрчлийн эрсдэлийн үнэлгээг хийж, нийт эрсдэлийг 25.1% гэж дүгнэсэн. Уг үнэлгээнд үндэслэн төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Эрүүл мэндийн газрын ажлын байрны шаардлагын талаарх сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулж, үр дүнд нь албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг 25%-иар нэмэгдсэн байна. Тайланд хугацаанд 5 удаагийн танхим 4 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 225 албан хаагч хамрагдсан байна. | Төрийн албаны хаагчийн ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа тогтмолжсоноор албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн, төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ухамсар, манлайллыг нэмэгдүүлж, ажлын байран дахь ёс зүйн эрсдлийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулсан байна. Ёс зүйн дэд хороонд албан хаагчдаас ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй бөгөөд ямар нэгэн ёс зүйн зөрчил, алдаа илрээгүй байна. | 100 |
| Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| 13 | Засгийн газрын тогтоол №2025-11-05 Дугаар 20, 2025-11-05 | 2027 оныг "Эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарлах тухай 2025-11-05 Дугаар 2025_154 | Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга | Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн төлөвлөгөө гаргаж, Аймгийн Засаг даргаар батлуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтын саналыг тусгуулахаар төлөвлөж байна. | Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хийх ажлын саналыг нэгтгэн авч санал авч нэгдсэн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | Эрүүл мэндийг дэмжих жил болгосноор эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж, иргэдэд хүрэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нарт даалгасугай. | | | | |
| 14 | Засгийн газрын тогтоол №151, 2025-11-05 | Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай | Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг хуульд заасны дагуу хариуцан санхүүжүүлэхийг БХ-ын сайд Д.Батлут, ХЗДХ-ийн сайд Б.Энхбаяр, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. | 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэс заслын вакум хагалгааны 2 өрөөг засварлаж 100 хувь ашиглалтад оруулан тусламж үйлчилгээг бүсийн хэмжээнд үзүүлэн эмнэлгийн тусламжийн аюулгүй байдал сайжирсан байна. Тайлант хугацаанд нийт 235 хүнд хагалгааг хийж мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 1 тэрбум 389,6 сая төгрөгийн их засварын хөрөнгө оруулалт хийгдэж, Уурхайчин багийн Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийн гадна шугам, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргэлтийн төвийн засвар, Гемодиализийн хэсгийн засвар, БОЭТ-ийн хагалгааны нэгдсэн тасгийн дээврийн засвар, Дэнж багт байрлах Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төвийн гадна фасад болон дээврийн засваруудыг тус тус хийж 100 хувь ашиглалтад орсноор эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх ээлтэй орчинг бүрдүүлсэн байна. | 2025 онд улс болон орон нутгийн төсвөөс эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийн засвар үйлчилгээнд төсөв тусгуулах, тендер зарлуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж төсвийн зарцуулалт бүрэн 100% зарцуулагдсан байна. | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэс засал, гемодиализийн тусламж үйлчилгээ болон 2 өрхийн эрүүл мэндийн төвийн барилга байгууламжид шаардлагатай засвар үйлчилгээ бүрэн 100% хийгдэж, эмнэлгийн тусламж үйлчилгээг ээлтэй чанартай үзүүлэх орчинг бүрдүүлсэн, 2025 онд төсөвлөсөн төсөв 100%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн байна. | 100 |
| 15 | Засгийн газрын тогтоол №147, 2025-10-29 | Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насний хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа, ажил хөдөлмөр эрхэлдэг эх, | Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчин 49-р долоо хоног томуугийн Цар тахлын хүндрэлийн үнэлгээгээр аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчин АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ ДЭГДЭЛТИЙН түвшинд шилжиж, БОЭТ-ийн хүүхдийн тасагт 135 хүүхэд хэвтэн эмчлүүлж байна.<br>Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид эмнэлгийн хуудас олгох зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>МУ-ын ЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 147 дугаар тогтоолыг | МУ-ын ЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 147 дугаар тогтоолыг олон нийт болон төрийн байгууллагын удирдлагууд, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх, хэвлэл, мэдээллийн сувгуудаар түгээх , хүүхдийн орны ачаалал, нягтралыг буулгах зорилгоор ЭМБ-уудаас томуу томуу төст өвчний улмаас ажлын 5 | Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насний хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эцэг, асран хамгаалагчид ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгохыг төсвийн байгууллагын дарга захирал, нарт даалгаж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын ажил олгогч нарт уриалсугай. | Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төв, ор бүхий клиникүүд, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, эм холбоо, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон төрийн байгууллагуудад И-оффисоор мэдээллийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагч томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асрахаар ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөөг авсан байна. | хоног хүртэл цалинтай чөлөө авсан эцэг эх асран хамгаалагчийн тоон мэдээлэлд анализ хийж, аймгийн төрийн байгууллагуудын ашигладаг И- оффис цахим мэдээллийн системд "Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн" үед өвчилсөн 6 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарч байгаа үед эцэг эх, асран хамгаалагчид ажлын 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө авах боломжтой тухай постер мэдээллийг ил тод байршуулан мэдээллийг түгээгээд байна. | ажил хөдөлмөр эрхэлдэг эх, эцэг, асран хамгаалагчид ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох нь хүүхдийн орны ачаалал, нягтралыг бууруулж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төв 3496 хүнд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн ба цахимаар тандалт хийсэн - 627 (17.9%), утсаар - 1450 (41.5%), гэрээр - 1419 (40.6%) тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. БОЭТ-өөр хүлээн авч үзүүлсэн, хэвтсэн 310 хүүхдийг утсаар тандсан байна. | |
| 16 | Засгийн газрын тогтоол №29, 2025-07-23 | МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ | 1.6.хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн соёл, спорт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд тайлбарлан ойлгуулах ажлыг тогтмол зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Д.Мөнхбатаар батлуулсан 2025 оны 04-р сарын 29-ны өдрийн "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн худалдаа, зохистой хэрэглээнд хамтарсан үзлэг хийх тухай" удирдамжийн дагуу Орхон аймгийн Тагнуулын газар, Орхон аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газрын холбогдох байцаагч, мэргэжилтнүүдийн хамтарсан 3 баг 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр нийтийн үйлчилгээтэй 74 эмийн сан болон Эрүүл мэндийн 24 байгууллагад /БОЭТ-ийн 2 тасаг, 9 СӨЭМТ-үүд болон хувийн хэвшлийн 14 эмнэлэгт/ 2025 оны 5-р сарын 6 өдрөөс 20 өдрийн хооронд Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, зарцуулалтад хяналт тавих, мэргэжил арга зүйгээр тогтмол хանган ажиллаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын сэжиг бүхий хэрэглээтэй иргэдийн мэдээллийг Цагдаа, Тагнуулын газар, Эрүүл мэндийн газрын Эм эмнэлгийн хэрэгслийн улсын байцаагч нартай харилцан солилцож, хамтарсан хяналтыг 2 жил тутамд 1 удаа хийхээр төлөвлөн,зөвлөмж өгч | Мансууруулах эм, сэтгэц нөлөөт эм борлуулах эрх бүхий аймгийн хэмжээнд Эм хանган нийлүүлэх 2 байгууллага, 12 эмийн сангийн бүртгэл, орлого, зарлага, үстгалд тогтмол хяналт тавиж, эргэн мэдээллээр хангаж ажилласан байна. 24 төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын Мансууруулах эм, сэтгэц нөлөөт эмийн бүртгэл зарцуулалтад улирал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эмийн эргэлтэд хяналт тавих тухай хууль-1, Засгийн газрын тогтоол-1, ЭМС-ын тушаал 4, стандарт-2, ЭМГ-ын даргын тушаал-1 тус тус мөрдөн 2 хяналтын хуудсаар нийт 16 заалтын дагуу үзлэг хяналт хийлээ. Хяналтаар: 98 байгууллагад үнэлгээ хийснээс Хангалттай сайн-12/12.24%/ Хангалттай-30/30.61%/ сайжруулах шаардлагатай-29/29.60%/ хангалтгүй-8/8.16%/ маш хангалтгүй-19/19.39%/ үнэлэгдсэн. Нийт байгууллагуудад 14 сайн тал, 16 дутагдал илэрсэн тул хэрэгжүүлэх 4 дүгнэлт гаргаж, 14 заалт бүхий 2 удаагийн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. | хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. | тутамд хяналт тавиж ажиллаж байна. Ингэснээр аймгийн хэмжээнд мансууруулах эм, сэтгэц нөлөөт эмийн хэрэглээ, зарцуулалтад бүрэн хяналт тавиж ажиллаж мэдээллийн урсгалын дагуу салбар байгууллагуудтай мэдээллийг шуурхай солилцож, хариу арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна. | |
| 17 | Засгийн газрын тогтоол №2025_279, 2025-06-04 | Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай | Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай. | Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ЭМГ-ын ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд 12 сард амралтын 2 өдөр нөхөн ажиллуулсан. | Амралтын өдрийг ажлын өдөрт шилжүүлэх зохицуулалт хийх хугацааны талаар удирдлагын багаар шийдвэр гаргаж, нийт албан хаагчдад мэдээллээр ханган хэрэгжилтэд хяналт тавиж ажилласан. | Баяр наадмын үеэр амарсан 2 өдрийг ажлын өдөрт шилжүүлэн ЭМГ-ын 33 албан хаагч, БОЭТ-ийн 513 албан хаагчдыг нөхөн ажиллуулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100 |
| 18 | Засгийн газрын тогтоол №67, 2025-02- | Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга | Орон нутагт яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн "112" дугаарлалтаар хүлээн авах үйл | 2025 онд нийт дуудлага -12102 ирснээс насанд хүрэгчид 9924 хүүхэд 2178 Яаралтай дуудлага-2586 (22%) Алсын дуудлага-90 (0.74%) Үр дүнгүй дуудлага-84 (0.7%) Түргэн тусламжийн дуудлага аваад | Тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ШУТ-ын бүтэц орон тоог 1 ээлжинд 3 оператороор | Яаралтай тусламжийн дуудлага мэдээллийн дугаарлалтыг улсын хэмжээнд нэгдсэн | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 05 | хэмжээний тухай | ажиллагааг Теле камерын хяналтын дэд төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | очсон хугацаагаар авч үзвэл: 0-20 минутад очсон -8535 буюу70.5% 21-40 минутад очсон- 2260 буюу 18,6% 41-60 минутад очсон-1302 ба 10.7% 1 цагаас дээш-5 буюу 0,04% ээзлж байна Дуудлагын шалтгаанаар авч үзвэл: -Зүрх судасны өвчлөл-3589 -Амьсгалын замын өвчлөл-1502 -Осол гэмтэл -905 -Архины шалтгаант-584 -Төрөх дуудлага ирсэн 142 бөгөөд бусад шалтгаантай дуудлагууд байна. БОЭТ-ийн түргэн тусламжийн эмч нар 103 дугаарын утсанд 4 ээлжээр дуудлага хүлээн авч байна | нэмэгдүүлэхээр хэлэлцэж, чадавхжуулах үйл ажиллагаанд хамтран ажиллахаар саналыг хүргүүлээд байна. Мөн бэлэн байдлыг хангахын тулд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг хүргүүлсэн байна. Аймгийн ШУТ-ийн үйл ажиллагааг тогворжуулах ажлын хэсгийн хурлаар Цагдаагийн газар 2025 онд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдлыг ханган ажиллахаар шийдвэрлэсэн. | "112" дугаарлалтад үе шаттайгаар шилжүүлэх тухай боловч хэрхэн ямар үе шатаар явуулах нь тодорхойгүй, аймаг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг байхгүй, санхүүгийн тогтвортой байдлыг хэрхэн хангах талаарх мэдээлэл дутмаг тул хэрэгжилтийг үнэлэх, авах арга хэмжээ тодорхой бус байгаагаас хэрэгжилт удаашралтай байна. | |
| 19 | Засгийн газрын тогтоол №217, 2024-12-18 | Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай | Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай. | Тайлант хугацаанд ЭМБ-уудын "Танилт, нэвтрэлтийн арга хэрэгсэл батлах тухай" 217 дугаарт тогтоолыг хяналтад авч үүрэгжүүлэн, ЭМБ-уудын удирдлагуудын шуурхайд танилцуулж, албан тоотоор хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг ЭМБ-уудад өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. ЭМБ-уудаас иргэд, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ ЗГ-ын 2024 оны А/217 дугаар тогтоолоор батлагдсан 1-р хавсралтын дагуу ашиглах өгөгдөлөөс регистерийн дугаар,биометрик өгөгдлийг ашиглан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулгалт хийдэг байна. Иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын системтэй тулган баталгаажуулахад хувь хүний регистрийн дугаар болон биометрик өгөгдлийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. | Орхон аймгийн Эрүүл мэндийн газраас 2024 онд салбарын хэмжээнд ажиллаж байгаа 152 байгууллагын 2089 албан хаагчдыг байгууллага тус бүрээр хуваарь гарган тоон гарын үсэг олгосноор нийт ажилтан албан хаагчдад 87 хувийг тоон гарын үсэгт хамруулсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд 24 байгууллагын 400 орчим эмч мэргэжилтнүүд танилт нэвтрэлтийн системийг ашиглаж байна. | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд танилт нэвтрэлтийн систем ашиглалтыг сайжруулснаар ЭМБ-уудын ачаалал буурч, үйлчлүүлэгчдэд хөнгөн шуурхай үйлчлэх болсоноор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өмнө оны мөн үеэс 5,7,0%-иар нэмэгдсэн. Тайлант хугацаанд танилт нэвтрэлтийн арга хэрэгслийн ашиглалттай холбоотой санал гомдол бүртгэгдээгүй бөгөөд тус тогтоолын хэрэгжилтэд ЭМГ-аас 2 удаа үнэлгээ хийж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмжөөр хангаж ажилласан байна. | |
| 20 | Засгийн газрын тогтоол №321, 2023-08-30 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 85,7 хувьтай хэрэгжсэн байна. 2025 онд нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нийт 237.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн хэрэгжилтийг хангахад АЗДТГ, БГ, ХГБХГ, ЦГ, ОБГ,Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ,Төрийн бус 10 байгууллагатай хамтран салбар дундын оролцоог хангаж ажилласан.Үүнд"Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" зорилгоор 2025 онд 31 удаагийн өдөрлөг, аян, форум, 276 удаагийн сургалт сурталчилгаанд 165 байгууллагын давхардсан тоогоор 110373 иргэнийг хамруулж, 55 төрлийн сурталчилгааны материалыг 9471 иргэнд түгээсэн, 1250 төрлийн гарын авлага, шторка, видео постер зөвлөмжийг түгээсэн байна.Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 110 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулан эрүүл зөв амьдралын мэдлэг хандлага, эрүүл мэндийн боловсролын түвшинг нэмэгдүүлсэн.Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний хүрээнд 38 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан 12 удаагийн өдөрлөгт сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршлыг бууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох чиглэлээр 31245 | Нэгдсэн төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд салбар дунын оролцоог хангах, мэдээллийн бүх сувгуудтай хамтран ажиллахаар төлөвлөн хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 44 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 165 аж ахуйн нэгж, байгууллага, 24788 иргэнийг хамрууллаа. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 41 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 9 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 7 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 38 аж ахуйн нэгж, байгууллага, 36452 иргэнийг хамруулан мэдлэг хандлага дадлыг нэмэгдүүлсэн байна. | Арга хэмжээнүүдийн хүрээнд нийт 27 удаагийн өдөрлөг, аян, форум, 316 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 20098 иргэнийг хамруулж, 24 төрлийн сурталчилгааны материалыг 6068 иргэнд түгээсэн.Цахим хуудаст 789 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 101318 хандалттай байгаа бөгөөд дээрхи арга хэмжээг зохион байгуулахад салбар дундын оролцоог хангаж ажилласан.<br>-Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 12 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүнийг хамруулсан байна. | | | |
| 21 | Засгийн газрын тогтоол №344, 2023-08-30 | "Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх тухай / | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр "Шүд угаах цаг"-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай | Амны хөндийн эрүүл мэндийг сахих, зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг өрнүүлж 24 сургуулийн 25122 хүүхдийг хамруулсан байна.Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад "Зөвийг дадал болгоё" шүд, гараа зөв угааж сурах аяныг өрнүүлж, Шүдний олимпиадыг улсын хэмжээнд анх удаа Шүдний холбоотой хамтран орон нутагт зохион байгуулж, нийт 630 хүнийг хамруулсан.Сургуулийн өмнөх 36 байгууллага нь 100% эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах орчинг бүрдүүлсэн, өдөрт 2 удаа амны хөндийг зайлах, шүд угаах сургалт нөлөөллийн ажлыг 100% хэвшүүлсэн. 17 ЕБСургуулийн 35%-д шүд угаах орчинг бүрдүүлсэн байна. Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрдэнэт клиник болон хувийн хэвшлийн 13 шүдний клиникт 120 эмч, эмнэлгийн мэргэжилтэн шүдний тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаагаас 61 буюу 50,8% нь их эмч ажиллаж байна | Тайлант хугацаанд ЭМГ,сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв, шүдний 13 клиниктэй гэрээ байгуулан сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх шүдний илрүүлгийн явуулын үзлэгт 29 багийн 22 сургуулийн 2433 хүүхдээс 94,4%-ийг хамруулсан. Үзлэгээр 2405 /99%/ хүүхдэд фторт түрхлэг түрхэж, шүдний цооролтой 1991 /81,8%/, шүдний гажигтай 673 /27,6%/, шүдээ бүрэн угаадаггүй 1974 /81.1%/,шүдний эмчилгээнд хамрагдсан 707/47,6%/хүүхэд байна. | Алслагдсан сум Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 51,0 сая төгрөгийн санхүүжилт бүхий шүдний кабинет байгуулагдсан бөгөөд Хаш шүдний эмнэлэгтэй гэрээ хийж, хамтран ажиллаж,Жаргалант ын 3-р сургуулийн 1 дүгээр ангийн 35 хүүхдийг шүдний үзлэг, фторт түрхлэгт хамруулсан байна.Хүүхдийн байгууллага дахь шүд угаах дэмжлэгт орчин 65%-д бүрдсэн, хүүхэд болон багш,эмч,эцэг эх асран хамгаалагчийн шүд угаах дадал ойлголт хандлага нэмэгдсэн. | 100 |
| 22 | Засгийн газрын тогтоол №67 2021-03-17 | Дүрэм шинэчлэн батлах тухай | 2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар | Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, 8 өрхийн эрүүл мэндийн төвийн арга зүйч 25 хүнийг хамруулан хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх ойлголт, урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгоход анхаарах зүйл зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан. | 2024 оны 12 дугаар сарын 17-нд баталсан Засгийн газрын 448 дугаар тогтоолыг холбогдох төрийн байгууллага, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвд хүргүүлж сурталчлан ажилласан. | Тайлант хугацаанд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нийт 48 удаа хуралдаж нийт 3520 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг шийдвэрлэсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | (Д.Зоригт), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | | | | |
| 23 | | | 3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан холбогдох дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цахимаар хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай. | Засгийн газрын 2023 оны 488 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-д заасны дагуу Эмнэлэг хяналтын комисс, Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь Эрүүл мэндийг дэмжих төвд 7 хоног бүрийн пүрэв, баасан гаригт хуралдаж байна. 2025 оны 1 дүгээр сараас эхлэн иргэн /даатгуулагч/-ийг өөрийн биеэр ирэхгүйгээр бичиг баримтад тулгуурлан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэдэг боллоо.Хуралд биечлэн оролцож буй эмч нар болон дуудагдсан иргэдийн тав тухыг хангаж сандал, хувцасны өлгүүр, ус буцалгагч, цайгаар тогтмол үйлчилж байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь улирал бүр эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө, өөрийн мэргэжлийн чиглэлээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон болон урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг Нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурал болгон дээр видео камер ажиллуулж хурлын файл болон бичлэгийг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд илгээн ажилласан. 2024 оны 1 дүгээр сард Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нартай гэрээ байгуулж авлига, ашиг сонирхол, ёс зүй хэм хэмжээний талаар заалт оруулсан. | Иргэн даатгуулагч нь хурлын дараа Нийгмийн даатгалын газар болон Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, банк явахгүйгээр материал нь хянагдаж 8-12 цагийн дотор тэтгэмж нь дансанд нь шилжиж байна. | 100 |
| 24 | | | 4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, даатгуулагч (иргэн)-ийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар орсон 1245 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэхэд нэг иргэний хуралд орох хүлээлгийн хугацаа 30-60 минут байна. 2022 онд хөдөлмөрийн чадвар алдалтаар хувь, хугацаа тогтоолгосон 3680 иргэн, 2023 онд 3434 иргэн, 2025 оны байдлаар 3520 иргэн байгаа нь жил тутам хөдөлмөрийн чадвар алдалтаар хувь, хугацаа тогтоолгож буй иргэдийн тоо 5-6%-аар буурч байгаа нь харагдаж байна. | Орхон аймгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байдал улсын дунджаас 1 промиллоор бага байна. Тайлант хугацаанд нийт 16 богино хэмжээний бичлэг бэлтгэн цахим хуудсанд байршуулан нийт 234347 хандалт авсан байна. | Шууд сургалт, live, утсаар зөвлөмж мэдээлэл өгөх үйлчилгээгээр хөдөлмөрийн чадвар алдалт болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар байнгын зөвлөгөө өгч хэвшсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | Засгийн газрын тогтоол №2024-163, 2024-11-13 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай | Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Тайлант хугацаанд 460 албан бичиг хүлээн авч 405 албан бичгийг хүргүүлж, цахим хэлбэрээр солилцон, хяналтад авч хэрэгжилтийг хангасан эсэх, шийдвэрлэлтийн явц байдалд тухай бүрт цахимаар (Able) хянаж ажилласан бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд И-оффис системийн ашиглалт 100% байна. Эрүүл мэндийн газрын албан хаагчдын цаг ашиглалтын хяналтыг сайжруулж, тогтмол цагаа бүртгүүлж и-оффисоор тогтмол хяналт тавьж байгаа бөгөөд үнэлгээ хийхэд ажлын цаг ашиглалт 65,5 %-тай байна.Тайлант хугацаанд хууль,тогтоомж зөрчсөн, сахилга бат, ажлын хариуцлага алдсан, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй байна. | Өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийг томилон ажиллуулж мэдээлэл болон холбоо барих утасны дугаар, өрөөний дугаар болон иргэдээс мэдээлэл, санал, хүсэлт, талархал, гомдол авах цагийн хуваарийг байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудасны "Санал гомдол" цэс болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулан мэдээлэл өгч ажилласан. | Тайлант хугацаанд албан хэрэгцээнд цахим программын ашиглалт сайжирч, шуурхай байдал хангагдсан байна. | |
| 26 | Засгийн газрын тогтоол №2024-109-1, 2024-10-02 | Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай | Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай | Аймгийн Эрүүл мэндийн газар, БОЭТ-д Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо байгуулагдсан. Тайлант хугацаанд 6 удаа хуралдаж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 23 ажлыг хийхээр төлөвлөн батлуулж үйл ажиллагааны хэрэгжилт 98%-тай байна. Үүнд:Эрүүл мэндийн газрын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмыг батлуулан,"Еннеаграм ба Урлагийн сэтгэл засал", хувь хүний хөгжил, сэтгэл зүйн сургалт "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" болон ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах шаардлагаар нийт албан хаагч дунд асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан. ЭМГ-ын албан хаагчдаас "Төрийн албан хаагчийн ёс зүйн тодорхойлох" асуулгыг цахимаар авч эрсдэлийг тодорхойлсон.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны тогтоолын хүрээнд ЭМГ-ын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, эрүүл мэндийн байгууллагуудын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороод, СӨЭМТ-үүдэд ёс зүйн багууд байгуулагдаж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ёс зүйн алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогмол зохион байгуулан ажиллаж байна. | Тушаал, шийдвэрүүдийг ёс зүйн хууль тогтоомжид нийцүүлэн баталснаар байгууллагын ёс зүйн соёл төлөвшиж, албан хаагчдын хариуцлага, мэдлэг, ойлголт дээшлэн дотоод зохион байгуулалт сайжирч, ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй байна.<br>4 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 271 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж үйл ажиллагааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэглээ хэлэлцүүлэгт ёс зүйн дэд хорооны дарга хамрагдаж "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал бүсийн зөвлөгөөн"-д ёс зүйн хорооны гишүүд болон албан хаагчид хамрагдсан. Ёс зүйн академитай хамтарсан "Ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх багц" сургалтад ЭМГ-ын 24 албан хаагч, БОЭТ-ийн 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж чадавхжсан. | Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо 4 удаа хуралдаж, 3 өргөдөл гомдолыг шийдвэрлэсэн. | хэрэгжилт 98%-тай байна. | |
| 27 | Засгийн газрын тогтоол №173, 2021-06-23 | Дүрэм шинэчлэн батлах тухай | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, санхүүгийн зохих дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлж, тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/347 дугаар захирамжийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тайлант хугацаанд 21 удаа хуралдаж нийт 391 хүүхдэд комиссын хурлаар орсон байна. Үүнээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 168, боловсролд 55, сунгалт 89, цуцлагдсан 38, шинээр орсон 69, буцаагдсан 28, бусад 112 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлөөс салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах 3 удаагийн цахим сургалтад бүх гишүүд хамрагдсан байна. Тайлант хугацаанд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд бага насны хүүхдийн хөгжлийн цогц үзлэгийг 2284 хүүхдэд хийж 79 хүүхдэд хөгжлийн хоцрогдлыг илрүүлж лавлагаа шатлалд илгээсэн.Эрдэнэт сувиллын цогцолбороос "Сэргээн засалт ба | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өсөлт, хөгжлийг дэмжих, тэдгээрийн асаргаа, хүмүүжлийн онцлогийг ойлгуулах зорилгоор Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (АШУҮИС) Сэргээн засах анагаах ухааны тэнхимтэй хамтран эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалт зохион байгуулсан.Тус сургалтаар хүүхдийн хөгжлийн онцлог, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн хөгжүүлэх арга зүй, хөдөлмөр засал, зөв байрлал, хооллолт болон булчин чангарлын менежментийн талаарх мэдээллийг 35 эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэсэн. | Хөгжлийн бэрхшээлтэй 2466 иргэнийг богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд, Солонгон ертөнц клиникт хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдийг урт хугацааны сэргээн засах эмчилгээнд тус тус хамруулан, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх асран хамгаалагч нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 2 удаа зохион байгуулснаар тэдний сэтгэл ханамж болон тусламж үйлчилгээнд ээлтэй орчин бүрдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөгжлийн бэрхшээл" өдөрлөгийг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхэд сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан. | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 28 | Ерөнхийлөгчийн зарлиг 2022-07-11 Дугаар 2022_159 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын иргэн бүр, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг гэрийнхээ хоймorт дээдлэн залж, хүндэтгэлтэй хандах нь зөвхөн түүхийн үнэ цэнийг мөнхжүүлэх явдал бус, ирээдүй хойч үеэ үндэсний бахархал, эх оронч үзлээр хүмүүжүүлэх, эх түүхээ дээдлэх сэтгэлгээний эх сурвалж тул эрүүл мэндийн салбарын удирдлагууд, 161 байгууллагуудад албан бичгээр уриалгыг хүргүүлсэн. | Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нийт 2000 гаруй эмч,эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаа 161 байгууллагад дээрхи уриалгыг Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудад танилцуулсан. Аймгийн хэмжээнд бүх төрийн байгууллага Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залсан байна. | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай зарлигийн хэрэгжилт хангагдсан байна. | 70 |
| 29 | Ерөнхийлөгчийн зарлиг 2019-05-30 Дугаар 2019_104 | Засгийн газарт чиглэл өгөх тухай | 16. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих | Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 24 сургуулийн орчинд 21 хүнсний дэлгүүр үйл ажиллагаа явуулж байгаа ба сургуулийн хоол зүйчид өөрийн орчны дэлгүүрүүдэд 14 хоног тутамд хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн Боловсролын газраас ЭМГ, ХХААГ-ын улсын байцаагч нартай хамтран Эрүүл мэндийн сайдын А/370 дугаар тушаалын дагуу "Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт"-ыг хүнсний дэлгүүрүүдэд хүргүүлж хэрэгжилтэд хяналт хийж ажилласан. | Тайлант хугацаанд Ерөнхий боловсролын 1,4,5,8, 17, Уран эгшиг -р сургуулийн орчны түргэн хоолны газар, түргэн үйлчилгээний 12 цэг салбар, сургуулийн ойролцоо байрлалтай хүнсний дэлгүүр, түц, мухлаг, Есөн -эрдэнэ худалдааны төв, нийт 25 цэгт Хүнсний чанарын хяналтын улсын байцаагч, Хүнсний эрүүл ахуйн хяналтын байцаагч хамтран 4 удаа төлөвлөгөөт бус шалгалт хийж, 75 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийн 46 буюу 61.3 хувийг газар дээр нь арилгуулж, зөвлөн | Хүүхдийн байгууллагын орчинд хориглосон хүнсний бүтээгдэхүүний борлуулалт 75,0%-иар буурсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тусалж ажилласан | | |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | | |
| 30 | Ерөнхий сайдын захирамж №Дугаар 20, 2025-08-13 | Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64 | Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай | Эрүүл мэндийн газрын Авлигын эсрэг 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 8 арга хэмжээний хүрээнд батлуулан хэрэгжилт 98,5% хувьтай байгаа нь өмнөх оноос 0,5%-иар нэмэгдсэн байна.Авлигатай тэмцэх газрын цахим системд олон нийтэд ил тод болгохоор заасан мэдээллээс эрүүл мэндийн салбарын ажилчид болон эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд хамаарагдах 5 зурган постер, 2 богино хэмжээний бичлэгийг Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим системд нээлттэй байршуулж нийт 8512 хүн үзсэн байна.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 201, Жаргалант сумын өрхийн эрүүл мэндийн төвийн 24, өрхийн эрүүл мэндийн 8 төвийн 84, нийт 309 эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг таниулах, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг хамтран зохион байгуулсан. | Авлигатай тэмцэх, ил тод байдлыг бэхжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаар холбогдох чиг үүргийг ЭМБ-уудын удирдлагууд болон ЭМГ-ын албан хаагчдын шуурхайд 4 удаа мэдээлэл хийж үүрэгжүүлэн сурталчилж ажилласан бөгөөд ЭМГ-ын төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн 2025 оны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтэд хяналт тавиж ажилласан.<br>Тайлант хугацаанд ЭМС-ын албан хаагчдаас авлига ,ашиг сонирхолтой холбоотой санал гомдол өргөдөл бүртгэгдээгүй байна. | ЭМС-ын нийт ажилтан,албан хаагчдын дунд авлигатай тэмцэх, ил тод байдлыг бэхжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан бөгөөд авлига,ашиг сонирхолтой холбоотой санал гомдол тайлант хугацаанд бүртгэгдээгүй байна. Тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 6 эрх бүхий албан тушаалтан хуулийн хугацаанд мэдүүлсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй албан хаагч бүртгэгдээгүй байна. | 100 |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 31 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №26, | Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-11- | Эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй хангалтгүй дүгнэгдсэн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэмжигдэхүйц шалгуур | Эрүүл мэндийн сайд, Засаг даргын 2025 оны хамтын гэрээний шалгуур үзүүлэлтэд 2025 оны 06, 11 сарын байдлаар үнэлгээ хийж, хангалтгүй хэрэгжсэн , хэрэгжилтэд анхаарах 13 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт,явц байдалд хийсэн үнэлгээг ЭМБ-уудын | Тайлант хугацаанд ЭМС, Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын гэрээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын 23 үзүүлэлтийн | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 23 шалгуур үзүүлэлтээс эхний хагас жилд хангалтгүй хэрэгжсэн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2025-11-05 | 05 2025_26 | үзүүлэлт бүхий төлөвлөгөө боловсруулах, салбарын хэмжээнд бодит үр дүнг сар бүр нэгтгэн дүгнэж, товч, тодорхой тайлагнах, өмнөх сард тайлагнасан албан даалгаварын хэрэгжилтийг давтан тайлагнахгүй байх. | удирдлагуудын шуурхай, Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлэл хийж, чиг үүргийн хүрээнд үүрэгжүүлэн сар бүр хэрэгжилтийг үнэлж , тайлагнаснаар хэрэгжилтийг сайжруулах 15 заалт бүхий төлөвлөгөө гарган ажилласнаар дээрхи шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт сайжирч, хүрэх түвшинд хүрч хангалттай үнэлэгдсэн байна.<br>Аймгийн Засаг дарга, өрхийн эрүүл мэндийн төвтэй 2025 хийгдсэн гүйцэтгэлийн гэрээний үнэлгээнд ажлын хэсгээр 2025 оны эхний хагас жил, сүүлийн хагас жил тутам үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангаж ажилласнаар 2025 оны гэрээний хэрэгжилтийн дундаж хувь 89,5% -тай үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6,8%-иар байна.Өрхийн эрүүл мэндийн 8 төв бүрт хангалтгүй дүгнэгдсэн, эрчимжүүлэх шаардлагатай заалтууд тухайлбал эрт илрүүлэг, идэвхтэй хяналтыг сайжруулах, эх хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын 23 үзүүлэлтийг сайжруулах, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг сайжруулж ажиллах чиглэл, зөвлөмжийг өгсөн байна. 2025 оны эхний хагас жилд нялхасын эндэгдлийн 10 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 5,1 п/м-ээр нэмэгдсэн тул нялхасын эндэгдлийг бууруулах 21 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. | хэрэгжилтийг сайжруулах 15 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 91,4%-тай хэрэгжсэн байна. АЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс Эрүүл мэндийн газрын 2024 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хэрэгжилт сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах 11 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилт 89,3%-тай хэрэгжсэн байна. сар бүр 5 хүртэлх насны хүүхдийн үзүүлэлтийг Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудын шуурхайд танилцуулан, хүүхдийн эндэгдэлд нөлөөлж байгаа хүчин зүйлийг бууруулах чиглэлээр 9 арга хэмжээг зохион байгуулсан. | 13 заалтын хэрэгжилт сайжирч 92,4%-тай үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0,8%- иар нэмэгдсэн. 2025 оны 12 сарын байдлаар 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор буурсан үр дүнд хүрсэн байна. | |
| 32 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №19, 2025-04-23 | Улаан бурхан өвчний дэгдэлтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар ЭМС танилцуулав | Улаан бурхан өвчний тандалт дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар | Улаанбурхан өвчний тархалтыг хязгаарлах хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан салбар дундын ажлын хэсэг, Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, эрсдэлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу | Тохиолдол удирдлагын тогтолцоонд шилжин эрсдэлийн үнэлгээ хийх, багуудыг мэргэжил арга зүйгээр хангах, эргэн мэдээлэх, тулгамдсан асуудлыг АОК-т тайлант хугацаанд 2 удаа танилцуулж, орон нутгийн 2025 оны | Орон нутгийн 2025 оны төсвөөс нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих зорилгоор 30 сая, Онцгой комиссын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хангаж ажиллахыг ЭМС Т.Мөнхсайхан, аймаг нийслэлийн засаг дарга нарт даалгав. | арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж, ажилласан. Орон нутгийн 2025 оны төсвөөс нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих зорилгоор 30 сая, Онцгой комиссын зардлаас 100 сая төгрөгийг шийдвэрлүүлж, бэлэн байдлыг хангасан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаагийн дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч, 93,6% хэрэгжүүлж ажиллалаа. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, халдвартын тасгийн эрчимт эмчилгээний хэсэг, тусгаарлан ажиглах өрөөний бэлэн байдалд салбарын хяналтын газрын төлөвлөгөөт бус шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр хамтарсан хурал хийн, шийдвэрлэж ажилласан. Зайлшгүй шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр гарган, үнэлгээ өгч ажилласан. Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан 2 удаагийн хурал, 7 удаагийн цахим сургалтад 376 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Улаанбурхан өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, холбогдох мэргэжлийн эмч, сувилагч, вакцинаторууд, хүүхдийн байгууллагын эмч нарт чиглэл тус бүрээр 4 удаагийн хурал хийж, үүрэг чиглэл өгч ажилласан. | төсвөөс нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих зорилгоор 30 сая, Онцгой комиссын зардлаас 100 сая төгрөгийг шийдвэрлүүлж, багаж тоног төхөөрөмж, оношлуур, дархлаажуулалтын зардлыг шийдүүлж эрүүл мэндийн байгууллагуудыг чадавхжуулсан . Халууралт, тууралттай хам шинжийн тандалт, улаанбурхан өвчний эмнэлзүй, илрэх шинж тэмдэг, ялган оношилгоо авах арга хэмжээний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан дотоодын сургалт 14 удаа зохион байгуулж, нийт эмч, эмнэлгийн ажилчдын 84,6% хамрагдсан. | зардлаас 100 сая төгрөгийг шийдвэрлүүлж, бэлэн байдлыг хангасан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаагийн дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч, 93,6% хэрэгжүүлж ажиллалаа.Шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, эрсдэлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж хариу арга хэмжээг шуурхай авч ажилласнаар 2025 оны 9 сараас хойш өнөөдрийг хүртэл улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. | |
| 33 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №28, 2025-11-24 | Томуу томуу төст өвчний хариу арга хэмжээг эрчимжүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгав | Эрүүл мэнд, сургалтын байгууллага болон нийтийн тээвэр, худалдаа, үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд амны хаалт заавал зүүлгэж, | Эрүүл мэндийн газрын даргын А/88 дугаар тушаалаар батлагдсан томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх Тохиолдлын удирдлагын баг нь тохиолдол удирдлагын тогтолцоонд шилжин салбар дундын уялдаа холбоог ханган ажиллаж, | Тохиолдол удирдлагын тогтолцоонд Эрүүл мэндийн салбар шилжиж, эрсдлийн харилцаа холбоог идэвхжүүлэн идэвхжлийн түвшинд тохируулан хариу арга | Томуугийн үеийн хүүхдийн тусламж үйлчилгээн дэх орны ачаалал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,4%-иар буурсан, ТТӨ-нөөс сэргийлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга нарт | эрсдлийн үеийн мэдээллийг шуурхай солилцон, өвчлөл, тархалт, нөхцөл байдалд эрсдлийн үнэлгээг 4 удаа хийж, хариу арга хэмжээний хэрэгжилт 95,6% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,2%-иар нэмэгдсэн байна.Эрүүл мэнд, сургалтын байгууллага болон нийтийн тээвэр, худалдаа, үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд амны хаалт заавал зүүлгэж, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахыг нийт төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад уриалан, Засаг даргын шуурхайд мэдээлэл хүргүүлэн, и оффисоор тогтмол ТТӨ-нөөс сэргийлэх сэрэмжлүүлэгийг оруулсан. | хэмжээг авч ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудас, хэвлэлийн байгууллагуудтай хамтран хүн амд хүргэх томуу томуу төст өвчнөөс сэргийлэх сургалт сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилт 91,5%-тай хэрэгжсэн байна. | сургалт сурталчилгааны хувь 6,1%-иар нэмэгдсэн байна. ЭМГ-ын пэйж хуудас, Сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв, БОЭТ-ийн пэйж хуудсаар ТТӨ-нөөс сэргийлэх 6 төрлийн сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж ажилласан. | |
| 34 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №28, 2025-11-24 | Томуу томуу төст өвчний хариу арга хэмжээг эрчимжүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгав | Иргэдэд зөвлөгөө өгөх, цахимаар цаг авах, хэвтүүлэн эмчлэхтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх "Нээлттэй утас" ажиллуулахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт<br>Салбар чиглэл:Эрүүл мэндийн чиглэлээр | Эрүүл мэндийн газрын даргын А/88 дугаар тушаалаар батлагдсан томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх Тохиолдлын удирдлагын баг нь тохиолдол удирдлагын тогтолцоонд шилжин салбар дундын уялдаа холбоог хангаи ажиллаж, эрсдлийн үеийн мэдээллийг шуурхай солилцон, өвчлөл, тархалт, нөхцөл байдалд эрсдлийн үнэлгээг 4 удаа хийж, хариу арга хэмжээний хэрэгжилт 95,6% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,2%-иар нэмэгдсэн байна. Томуугийн салбар дундын ажлын хэсэг 4 удаа хуралдан томуугийн тархалтын түвшинтэй уялдуулан хариу арга хэмжээг авч ажиллаж байна.2025 оны 12 сарын 10-ны байдлаар тархалтын түвшин “Аймгийн түвшин”-д шилжсэн тул өрхийн эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагийн зохицуулалтад оруулан, зорилтот бүлгийн хүн амд гэрийн эргэлтэд шилжин тусламж үйлчилгээг үзүүлж байна. | ТТӨ-ний салбар дундын багийг 2 удаа,Тохиолдол удирдлагын баг 3 удаа хуралдаж, шийдвэрийн хэрэгжилт 87,5%-тай, ТТӨ-ний хариу арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийсэн.<br>Эрсдлийн үнэлгээг 2 удаа хийж "Өндөр эрсдэлтэй" үнэлгдэж, зөвлөмжийг ЭМБ-уудад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.Хариу арга хэмжээний хүрээнд ЭМБ-ууд болон салбар байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн томуугийн үеийн тусламж үйлчилгээнд 1 удаа дэмжлэгт хяналт хийж зөвлөмж хүргүүлсэн байна. | Сум,8 өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв 100% ТТӨ-ний чиглэлээр иргэдэд зөвлөгөө өгөх, цахимаар цаг авах, хэвтүүлэн эмчлэхтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх "Нээлттэй утас"-ыг ажиллуулан тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж 684 хүнд үйлчилсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №28, 2025-11-24 | Томуу томуу төст өвчний хариу арга хэмжээг эрчимжүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгав | Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Нэгдсэн эмнэлэг / бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн вирус судлалын салбар лабораторийг вирусын геномын дараалльг тогтоох болон үүсгэгч илрүүлэх урвалж, оношлуураар хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулахыг ЭМС, Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Томуу томуу төст өвчний үеийн хариу арга хэмжээний хүрээнд Аймгийн онцгой комиссын шийдвэрээр батлагдсан 131 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2000 ширхэг түргэвчилсэн оношлуур, 7 төрлийн багаж тоног төхөөрөмж, Н95 амны хаалт 1000 ширхэгийг ЭМБ-уудад хуваарилан томуугийн тусламж үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлсэн. Орон нутгийн 2025 оны төсөвт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээг чадавхжуулах зорилгоор 55 сая төгрөгийг төсөвт тусгуулан хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлсэн. | Аймгийн онцгой комисст 2 удаа ТТӨ-ний үеийн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тулгамдаж байгаа асуудлыг танилцуулан 2025 онд томуугийн оношлуур болон нэмэгдэл ажлын хөлсөнд 55,0 сая , томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс томуугийн бүртгэл мэдээний чанарыг сайжруулах зорилгоор компютер техник хэрэгсэлд 20,0 сая төгрөгийг шийдүүлэн хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлсэн. | Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 91%-тай байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 94%-тай байна. | 100 |
| 36 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №2025_13, 2025-08-20 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл | 12.3.2.4.. дотоод орчны агаарын чанарын стандартыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан батлуулж, агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн | 2025-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 24 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 39 нийт 63 байгууллагад 36272 хүүхэд суралцаж байна. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2025-2026 оны хичээлийн жилийн бэлтгэл, ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Ерөнхий боловсролын 1, 4, 5, 7, 13, 16, 18, 20, Уран эгшиг, Ирээдүйн одод, Жаргалант сумын сургууль, дотуур байр, Сургуулийн өмнөх боловсролын 3, 4, 15, 17, 21, 24, Оюу, Унага, Баян-Өндөр, Бяцхан одод, Миний гэр, Яргуй эко цэцэрлэгүүд болох нийт 26 объектыг хамруулав. Тус шалгалтаар анги танхим бүрт дотоод орчны бичил цаг уур хэмжигч 12 буюу 46% нь суурилуулсан. Анги танхимын агаар сэлгэлтийн байдалд физик хэмжилтээр үнэлэхэд агаарын солилцоо хангалттай явагдах нөхцөлтэй, салхивч нь чөлөөтэй нээгдэж, хаагддаг, энгийн агааржуулалтын системтэй. Оюу, Унага, Баян-Өндөр, | Эрүүл мэндийн сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны А/05, 08 дугаар хамтарсан Барилгын материалын эрүүл ахуйн, аюулгүйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг батлах тухай тушаалын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2025 оны 06, 11 сард бүх шатны боловсролын байгууллагад зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Зөвлөмжид тусгасны дагуу сургууль, цэцэрлэгүүд эко будгийг сонгон засвар үйлчилгээ хийсэн байна.<br>Аймгийн хэмжээнд Хүүхдийн байгууллагуудад | Үнэлгээнд хамрагдсан нийт 26 хүүхдийн байгууллагын анги танхим бүрт дотоод орчны бичил цаг уур хэмжигч 12 буюу 46% нь суурилуулж, засвар үйлчилгээнд хүүхдийн эрүүл мэндэд ээлтэй эхо будгийг хэрэглэсэн байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгөөс гаргахыг холбогдох Засаг дарга нарт тус тус; Салбар чиглэл: Нийгмийн бодлого | Бяцхан одод, Миний гэр цэцэрлэгүүдийн дотоод орчны агаараас дээж авч лабораторид шинжлүүлэхэд цус задлагч кокк, нян зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй үзүүлэлттэй гарсан. Сургууль, цэцэрлэгүүд дотоод болон гадаад орчны агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор 27 зөрчилд улсын байцаагчийн 4 албан шаардлагыг хүргүүлж ажилласан. Албан шаардлагын биелэлт 74,4 хувьтай хэрэгжсэн байна. | дотоод орчны агаарын байдалд хийсэн 1 удаагийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийн хангалт болон албан шаардлагын биелэлт 74,4%-иас доош байгаа 5 хүүхдийн байгууллагуудад давтан хяналт хийж зөвлөмж өгч ажилласан. | | |
| 37 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №09, 2025-07-23 | Гэдэсний халдварт өвчин, хоолны хордлогот халдварын өнөөгийн нөхцөл байдал, авах арга хэмжээний талаар ЭМС танилцуулав. | Үүнтэй холбогдуулан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, хүнсний худалдаа үйлчилгээ, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, эрүүл мэндийн байгууллагын үйл ажилллагаа, эснэлгийн тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллахыгн ЭМС Ж.Чинбүрэнд үүрэг болгов. | Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, хүнсний худалдаа үйлчилгээ, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг сайжруулах арга хэмжээг тасралтгүй авч гэдэсний халдварт өвчин, хоолны хордлогот халдвараас сэргийлэхэд хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хяналт шалгалтад нийт 769 объектыг хамруулснаас төлөвлөгөөт, хяналт хамрагдсан 61 объектод 100 хувь зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог хэвшүүлснээс хоол үйлдвэрлэлийн 50 байгууллага үүнд нийтийн хоол үйлдвэрлэлийн 5, эмнэлгийн 13, сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн 32 , хүнсний үйлдвэр 5, цэвэр усны 2 үйлдвэр, бялуу, нарийн боовны 4 үйлдвэрт үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн бүртгэлээр тавих 9 хяналт, шинжилгээгээр баталгаажих 8 үзүүлэлтийг шаардлага хангуулж, 73 заалттай 15 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан үр дүнд хүрсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан 708 объект болон газар | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хоол үйлдвэрлэлийн ажлын байранд эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөл байдалд улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлснээр ажлын байранд засвар хийх зардлыг шийдвэрлүүлэн зураг төслийн шатанд байна. 261 заалттай хамтарсан 9 актаар хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 21 төрлийн 878.000 төгрөгний 285 ширхэг эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнд акт үйлдэж хураан авч, 223.200 төгрөгийн хэрэглэх хүчинтэй хугацаа дуусахад 2-10 хоног үлдсэн болон болон бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал алдагдсан, хугацаа дууссан 13 төрлийн 90 ширхэг 1.702.000 | Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлийн хурлаар 4 удаа хэлэлцүүлж эрсдэлийг бууруулах бодлого чиглэлийн 4 шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн. Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд хяналт шалгалтад шаардлагатай 98 объектын болон нутаг дэвсгэрийн 5 байршлын хөрсний 6 төрлийн шинжилгээний 557 дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулах 6.000.000 төгрөгийн зардлыг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хөрөнгө гаргах тухай А/316 захирамж гарч, хяналт шалгалтаар нотолгоонд суурилсан дүгнэлт, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дээр нь эрсдэлийн үнэлгээ хийгдсэн 381 объектоос нийт 825 объект буюу аж ахуй нэгж, иргэний хүнсний үйлдвэрлэл, худалдааны 3292 дээжийг Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораторит шинжлүүлэн шаардлага хангаагүй сорилын дүнтэй гарсан 101 дээжийг бүртгэл хяналтад авч устгуулан, давтан шинжилгээнд хамруулж шаардлага хангуулсан. Хяналт шалгалтаар 444 объектод буюу 62,7 хувьд нь баталгаажуулсан бүтээгдэхүүн үйлчилгээг хэвшүүлэн өмнөх оныхоос түвшнээс 5,8 хувиар нэмэгдүүлж зорилтот түвшинд хүрсэн үр дүнтэй байна. | төгрөгний үнэ бүхий бүтээгдэхүүнийг газар дээр нь устгуулсан байна. Хяналт шалгалтаар CU сүлжээний 4 салбар, хоол үйлдвэрлэлийн 4, хоол, хүнсний худалдан борлуулдаг 11 иргэнд нийт 16750000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч барагдуулан илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан үр дүнд хүрсэн. 8, 15 дугаар сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрын өртөтгөлийн зураг төслийн хяналт хийж, ашиглалт авах комисст ажилласан. | эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажилласан үр дүнтэй байна. | |
| 38 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл №2025_26, 2025-06-04 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл | 26.27.6.2.Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх, үндэсний товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах хүрээнд Аймгийн Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан салбар дундын ажлын хэсэг, Эрүүл Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, эрсдлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судлагаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж, ажиллалаа.Улаанбурхан өвчний сэжигтэй 86 тохиолдол бүртгэгдэж, 66 тохиолдол батлагдаж, хариу арга хэмжээг авч ажилласан. ЭМГ-ын гамшгийн нөөцөд 1 нэр төрлийн 4,81 сая төгрөгийн эм, 5 төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгслийн 4,6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй | Сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьталд тандалт судалгаа хийж, голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих 347 /96.9%/ хүнийг дархлаажуулалтад хамруулсан. Аймгийн хэмжээнд улаанбурханы эсрэг 3 төрлийн вакцины 1430 хүн тун нөөцтэй байна. Анхан болон лавлагаа шатлалын 12 байгууллагын Улаанбурхан өвчний хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ, дархлаажуулалт, халдвараас сэргийлэх хариу арга хэмжээнд | Хариу арга хэмжээний чадавхи нэмэгдэж, салбар дундын оролцоог ханган эрсдэлийн харилцаа холбоог идэвхжүүлж ажилласнаар 2025 он 9 сараас хойш одоог хүртэл улаан бурханы тохиолдол бүртгэгдээгүй байна.<br>Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад 745 хүүхдийг хамруулж, 1774 хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд нөхөж оруулан, хамралт 39%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 91%-тай байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 94%-тай байна. Сар шинэ, улсын баяр наадам болон томуу томуу төст өвчин, улаанбурхан өвчнөөс сэргийлэх сэрэмжлүүлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээний зураглалыг орон нутгийн хэвлэл мэдээлэл, ЭМГ-ын цахим хуудсаар, ЭМБ-уудын вэб хуудсаар 12 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 45604 хүний хандалт авсан байна. | ЭМГ-аас дэмжлэгт хяналт, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр 4 удаа ханган, танхимын болон цахим сургалтад 94 эмч,эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан | | |
